



ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Европын баривчлан саатуулах тушаал буюу түр баривчлан саатуулах баримт ирсэн эсвэл албадан гаргах өргөдөл ирсэн хүнд олгох

Та Европын түр баривчлан саатуулах тушаал буюу түр баривчлах баримт ирсэний улмаас Давж заалдах шүүхийн нэгдүгээр ерөнхий шүүгчийн шийдвэрээр эрх чөлөөгөө хасуулан хоригдсон. Уг баримт нь таны эдлэх гол эрхийг танд сануулж байгаа болно.

Та үг баримтыг өөрийн хоригдох хугацаанд хадгалж болно

Гэмт үйлдлийн танилцуулга

Та өөрийн хийсэн гэх хэргийн зүйлчлэл, огноо ба газар байршилийг мэдэх эрхтэй ба мөн таныг урьдчилан хориход хорисон шалтгааныг мэдэх эрхтэй.

Өмгөөлөгчийн туслалцаа

Та өөрийн сонгосон өмгөөлөгч буюу улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцааг авахаар хүсэлт гаргах эрхтэй.

Та өөрийн өмгөөлөгчтэй бичгээр буюу чөлөөтэй харилцах эрхтэй ба тэр таны бүх байцаалтанд дуудагдан оролцоно. Тэр таны баримт бичигтэй танилцах эрхтэй.

Үг хэлэхгүй байх эрх

Шүүхийн өмнө та мэдүүлэг өгөх, асуусан асуултууданд хариулах ба дуу хураан үг хэлэхгүй байх эрхтэй.

Хэлмэрчийн туслалцаа

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Даатгуулан гардуулахыг зөвшөөрөх боломж

Таныг эрэн сурвалжилж байгаа улсад даатгуулах эсэхийг та зөвшөөрөх ба эс зөвшөөрөх эрхтэй. Зөвшөөрсөн тохиолдолд, хэрэг бүрдүүлэх эрүүгийн танхим нь маш богино хугацаанд шийдвэрлэх үүргийг хүлээнэ. Хэрэв та Европын Холбооны Шүүхийн Байгууллагын саатуулах баримтыг зөвшөөрч байвал цаашид таны уг шийдвэр өөрчлөгдөхгүй.

Та чөлөөлөгдөн суллагдах гарах эрхээ шаардах ба эрх чөлөөг хасах хугацаа

Тус хугацаа нь та өөрийгөө даатгуулан гардуулан гаргах үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч байгаа эсэхээс шалтгаална.

Ямар ч үед та өөрийнхөө суллагдах талаар хэрэг бүрдүүлэх эрүүгийн танхимд хүсэлт тавих эрхтэй.

Зарим хүний талаархи мэдээлэл

Та өөрийн хүсэлтээр өөрийн гэр бүлийнхэндээ ба ойр дотнын хүмүүсдээ хоригдож

буй талаар мэдээллэх эрхтэй.
Хэрэв та гадаад улсын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

Эмчийн үзлэг

Та эмчийн үзлэгээр орох хүсэлт гаргаж болно.